

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хийж, гаргасан санал дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Төслийг Байнгын хороогоор хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг утаат тамхи татахыг хориглосон газраас бусад гадаад орчин дахь нийтийн эдэлбэр газарт байгуулах утаат тамхи татах цэгийн байршил, төсвийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэдэг байх, нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газар болон аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны дотоод орчинд утаат тамхи татах цэгийг 300 м<sup>2</sup>-аас доошгүй талбай бүхий барилга, байгууламжид нэгзээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, албан байгууллага байгуулж болно гэж хуулийн төсөлд нэмж тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь “300 м<sup>2</sup>-аас доошгүй талбай” гэдгийг “200 м<sup>2</sup>” гэж багасгах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл жижиг талбайтай аж ахуйн нэгж, албан байгууллагад утаат тамхи татах цэг байгуулах нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн саналыг гаргав.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, саналын томьёоллыг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

Д.БАТЦОГТ

